

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ОРЧИН БА БОЛОМЖУУД**
/Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны
агентлагийн дарга Б. Ганзоригийн тавих илтгэл/

Эрхэм зочид, төлөөлөгчдөө,
Хатагтай, ноёдоо,

Монгол Улсын Засгийн газраас Улаанбаатар хотноо зохион байгуулж буй “Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт 2006”-гийн урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Юуны өмнө энэ удаагийн чуулга уулзалтыг хамтран зохион байгуулж байгаа Евроманийконференцис, Монгол Банк болон биднийг дэмжин ажилласан бүх байгууллага, хүмүүст талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

Чуулга уулзанд Энэ чуулга уулзанд нийтдээ 790 зочид, төлөөлөгч оролцож байгаагаас 421 нь гадаадын, 369 нь дотоодын хүндэт зочид, бизнес эрхлэгчид байна. Гадаадын 35 орны төлөөлөгчид Банк, санхүү, хөрөнгө оруулалт, Хүнд үйлдвэр, Эрчим хүч, Аялал жуулчлал, Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэр, дэд бүтцийн болон бусад салбарыг сонирхож энэхүү арга хэмжээнд оролцож байгаад талархаж байна.

I. Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

Монгол улсын Засгийн газар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг УИХ-аар хэлэлцэн 1990 онд анх баталж 1993, 1998 болон 2002 онуудад нэмэлт өөрчлөлтүүд оруулсан бөгөөд эдгээр нь хөрөнгө оруулалтын тааламжтай орчинг бий болгох, олон улсын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн жишигт ойртуулахад чиглэгдсэн юм.

Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль, тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглох, гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад монголын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгодог. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу дэд бүтэц, боловсруулах, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл эрхэлж байгаа хөрөнгө оруулагчдад орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлт олгож, технологийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн ба НӨАТ-ийн чөлөөлөлт олгож байгаа.

Монгол улсын Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх илүү тааламжтай орчинг бий болгох, асуудлыг аль болох хурдан шуурхай шийдвэрлэх, хүндрэл бэрхшээлийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, тухайлбал, 2001 онд батлагдсан Тусгай зөвшөөрлийн тухай хуулиар бизнес эрхлэхэд шаардагдах лицензи, зөвшөөрлийн тоог 600-гаас 87 болтол бууруулсан юм. Гаалийн Ерөнхий Газраас гадаад худалдааг хөнгөвчлөх e-customs систем нэвтрүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох, албан бус эдийн засгийг бууруулах, хөрөнгө оруулалтын орчинг олон улсын жишигт ойртуулах зорилгоор 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс татварын багц хуулиудын өөрчлөлтийг 2006 оны 6 дугаар сард баталлаа. Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хувь хэмжээ тус бүр 5 пунктээр буурч, 10, 25% болсон нь хөрөнгө оруулагчдад томоохон хөнгөлөлт болсон гэж үзэж байна.

Саяхан баталсан Ашигт малтмалын тухай шинэчилсэн хууль нь бүхэлдээ Монгол орны эрдэс баялгийг илүү үр ашигтай ашиглах, нэмүү өртөг бий болгох боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд томоохон хөрөнгө оруулалтын хувьд гадаадын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран Монгол Улсын Засгийн Газартай тодорхой хугацаанд "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулах хүсэлт тавьж болох бөгөөд энэхүү гэрээ нь бизнесийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн баталгаа болно.

Хөрөнгө оруулалтыг татах суурь нөхцлүүдийн нэг болох дэд бүтцийг хөгжүүлэх талаар төр, засгаас дэс дараатай бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнд гадаад, дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа мэдээлэл харилцаа, зам тээвэр, эрчим хүчний салбарын төслүүдийг дурьдаж болно. Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа ч тогтворжин сайжирч, иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээ эрс нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын таатай нөхцөл болох эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк байгуулах хууль, эрх зүйн орчин бүрдлээ. Өнгөрсөн долоо хоногт Алтанбулагийн чөлөөт бүсийн захиргаа АНУ-ын компанитай хөрөнгө оруулалтын анхны гэрээнд гарын зурсан тухай мэдээлэхэд таатай байна.

Европын Холбооны зах зээлд 7200 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортын тэг тарифтай оруулах GSP+ нөхцөлд Монгол Улсыг хамруулсан нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар худалдааны энэхүү тааламжтай нөхцлийг харилцан ашигтай хэрэглэх бололцоо олгож байна.

Монгол улсын Засгийн газар нь "Давхар татвараас чөлөөлөх тухай" хэлэлцээрийг 33 улстай, "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр"-ийг 39 улстай байгуулсан ба "Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" 1965 оны Вашингтоны конвенцид 1996 онд, "Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай" 1985 оны Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон.

Түүнчлэн Монгол улс нь Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн /MIGA/ гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчид MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй.

Монгол Улсын төр засаг эдгээр эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлснийг олон улсын байгуулагууд давхар баталж байгаа билээ. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас дэлхийн 140 орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадварыг үнэлэхэд Монгол улс энэ үзүүлэлтээр харьцангуй их хөрөнгө оруулалт татаж чадсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй өндөр чадавхитай орнуудын жагсаалтанд багтах болсон байна. Манай орны зээлдэх зэрэглэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Фич, Мүүдиз, Стандарт энд Пүэрс байгууллагууд В+ хэмээн тогтоосон билээ.

Дэлхийн Худалдааны Байгууллагаас манай улсын худалдааны бодлогыг 2005 онд хянаад *Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь тогтвортой, инфляцийн боломжийн түвшинд* байна гэж дүгнэлээ. Дэлхийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорацитай хамтарч 175 улс орны бизнес эрхлэх хууль тогтоомжид хийсэн *Doing Business 2007* судалгаагаар Монгол Улс нь бизнес эрхлэхэд хүндрэл багатай орнуудын эхний 45-д бичигдсэн байна. Эдгээр нь хөрөнгө оруулалтын орчин манай улсад таатай байгааг давхар баталсан явдал гэж үзэж байна.

II. Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын төр, засгаас явуулж буй гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн тууштай бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж түүний

нийгэм, эдийн засгийн үр нөлөө мэдэгдэхүйц болж ирлээ. Хамгийн сүүлд 2002 онд зохион байгуулсан хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтаас хойш Монгол Улсад орох гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ жил тутам нэмэгдэж өссөн дүнгээр Монгол Улсын гадаадаас авах зээл тусламжийн хэмжээтэй тэнцүү буюу 1,5 тэрбум ам.долларт хүрсэнийг тэмдэглэхэд таатай байна. 1995-96 оны түвшинд жилдээ 30-40 сая орчим ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдэж байсан бол эдүгээ зөвхөн нэг жилд 300 саяаас дээш ам.долларын хөрөнгө оруулалт орох болсон байна. Тухайлбал, 2005 онд 311 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Өнөөдрийн байдлаар 1990 оноос хойш дэлхийн 96 орны 5777 гадаадын хөрөнгө оруулалттай компани нийт нэг тэрбум таван зуун сая гаруй ам.долларын шууд хөрөнгө оруулалт Монголд бүртгүүлсний 80 шахам хувь нь зөвхөн 2000-2005 онуудад хийгдсэн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаар авч үзвэл геолог хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт ГШХО-ын 43,8 хувь, хөнгөн үйлдвэрт 5,6%, банк санхүүгийн үйл ажиллагаанд 5,5%, барилгын үйлдвэрлэлд 3,5%, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтанд 5,5%, үлдэх хувь нь худалдаа, үйлчилгээний болон бусад салбарт орсон байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ, Канад, БНСУ, АНУ, Япон, ОХУ, Их Британи Умард Ирландын хөрөнгө оруулагчид эхний байруудад байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхэд шинэ хөрөнгө оруулагчдаас гадна Монголд хөрөнгө оруулаад үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчид дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулж бизнес эрхлэх муугүй нөхцөл байгааг харуулж байгаа хэрэг бөгөөд үүнийг ч олон улсын байгууллагаас давхар нотолж байгаа билээ.

III. Гадаадын хөрөнгө оруулалтын боломжууд

Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн мөрдөж байгаа хуулиар хар тамхи, зэр зэвсэг үйлдвэрлэх, садар самууныг сурталчлах зэрэг хуулиар хориглосноос бусад салбарт хөрөнгө оруулалт хийх өргөн боломжтой.

Монгол орон алт, зэс, уран, нүүрс, молибден, фосфор, газрын тос болон бусад байгалийн арвин их баялагтай, байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж болох газар тариалангийн 1.3 сая гектар талбайтай, 30 гаруй сая толгой малтай.

Ази, Европын геостратегийн уулзварт оршдогийн хувьд Монгол Улс нь бүс нутгийн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төсөл, хөтөлбөр, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх, бүс нутгийн эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд анхаарч байна.

Засгийн газраас мэдээлэл технологийн салбарт өндөр ач холбогдол өгч, боловсролын салбарыг мэдээллийн хувьсгалд зохицуулан бүтцийн өөрчлөлт хийж, улмаар дэлхийн зах зээлд хэрэгцээт программ боловсруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ, боловсролын түвшинг дээшлүүлэн чанаржуулах, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн дэлгэрүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна.

Өнөөдөр мэдээлэл, холбооны технологийн үсрэнгүй хөгжлийн үр шимийг Монголын хэрэглэгчид хүртэж мянган хүнд оногдох компьютер, гар утас, их дээд сургуулийн оюутны тоогоор харьцангуй дээгүүр үзүүлэлттэй байна.

Монгол орон үзэсгэлэнт онгон байгальтай, эрт дээр үеэс уламжлагдан үлдсэн түүх, соёлын өвөрмөц иргэншилтэй орон учир аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтойг

"Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн жил"-ийн хүрээнд 2006 оны эхнээс олон арван арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаагаас харж болно.

Энэ бүхнээс үзэхэд Монгол орон нь бүс нутгийн томоохон хэмжээний дэд бүтцийн, манайд буй эрдэс баялаг, малын гаралтай натурал түүхий эдийн арвин их нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийн болон бусад төслүүдийг хэрэгжүүлэх, мөн хөрш хоёр орны асар том зах зээлд гарч өрсөлдөх боломж нээлттэй болох нь харагдаж байна.

Засгийн газраас хөрөнгө оруулалт эрэлхийлсэн томоохон төслүүдэд анхаарч Хүнд, Хөнгөн үйлдвэр, Чөлөөт бүс, Хүнс хөдөө аж ахуй, Түлш эрчим хүч, Барилга, хот байгуулалт, Мэдээлэл, харилцаа холбоо, Зам тээвэр, аялал жуулчлалын гэсэн 8 салбарын Засгийн газрын 43 төслийг нэгтгэн ном болгон хэвлүүлэн Та бүхэнд толилуулж байгаагаас гадна хувийн хэвшлийн 40 гаруй төслийг нэгтгэн авч Чуулга уулзалтын веб хуудсанд байрлуулан танилцуулж байна.

Хэрэгжиж эхлээд байгаа тухайлбал, 2008 онд ашиглалтад орох Чойр – Замын-Үүдийн замын, Алтанбулагийн чөлөөт бүсийн, Тайширын, Эгийн голын усан цахилгаан станцуудын, 40 000 айлын орон сууцны, усалгаатай тариалангийн, эрдэс баялагийн олборлолт, боловсруулалтын зэрэг томоохон төслүүд нь хөрөнгө оруулалтын бодит боломж, ирээдүй байгааг харуулж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ удаагийн чуулга уулзалт амжилттай болж та бүхэн ашиг орлого арвинтай гэрээ хэлцэл байгуулж, хамтарсан компаниа Монгол улсад байгуулна гэдэгт итгэж байна. Та бүхэнтэй байгуулагдаад 10 жилийн нүүр үзэж байгаа, олон улсад тодорхой хэмжээнд танигдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг хамтран ажиллахдаа таатай байх болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.